ОЛОН УЛСЫН ХУДАЛДАА БА ДИЖИТАЛ МАРКЕТИНГ СУРГАЛТ

Модуль 1 – Анхан шатны суралцагсдад зориулсан сургалтын хөтөлбөр

Аж үйлдвэрийн IV хувьсгалын эрин үед иргэн, аж ахуйн нэгж, бизнесийн байгууллагууд гадаад зах зээлд нэвтэрч, бизнесээ удирдан явуулахад олон сорилт бэрхшээл тулгарч байна. Үүнийг даван туулахын тулд олон улсын худалдааны үндсэн ойлголтоо өргөжүүлэх, гадаад худалдаатай холбоотой бодлогын арга хэрэгслийг танин судлах, гадаад худалдааны тоон өгөгдөл дээр ажиллаж дүн шинжилгээ хийх, зах зээлийн анхдагч суурь судалгаа (market intelligence study) хийх арга, чадварыг эзэмших шаардлага үүсэж байна. Түүнчлэн дижитал маркетингийн стратеги боловсруулах, мэргэжлийн программ ашиглан бүтээлч зар сурталчилгаа бүтээх зэрэг суурь мэдлэг, ур чадварыг эзэмшиж, дадлагажих хэрэгцээ улам бүр нэмэгдэж байна.

СУРГАЛТЫН ҮНДСЭН АГУУЛГА

1. Олон улсын худалдаа: Гадаад зах зээлд нэвтрэх боломж, саад бэрхшээл ба өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх нь

Зорилго: Жижиг, дунд бизнес эрхлэгчдэд гадаад зах зээлийн боломжийг тодорхойлох, худалдааны саад бэрхшээлийг ойлгох, өгөгдөлд суурилсан шийдвэр гаргах мэдлэг, ур чадвар олгох.

- **Гадаад зах зээлд нэвтрэхэд тулгардаг саад бэрхшээл**
  - Тарифын зохицуулалт: гаалийн татвар, тарифын хувь хэмжээ, худалдааны хэлэлцээр
  - Тарифын бус арга хэмжээ: импортын квот, техникийн стандарт, тохирлын үнэлгээ, эрүүл ахуй, хорио цээрийн шаардлага
- **Өгөгдөлд суурилсан зах зээлийн судалгаа, шинжилгээ**
  - Жижиг, дунд бизнесийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд өгөгдөл ашиглах
  - Зах зээлийн эрэлт, хэрэглэгчийн зан төлөв, өрсөлдөгч болон үнийн судалгаа хийх
  - Экспортын боломж, эрсдэл, зорилтот зах зээлийг тодорхойлох
- **Market Intelligence – Зах зээлийн мэдээлэл цуглуулах, боловсруулах аргачлал**
  - Олон улсын худалдааны мэдээллийн сан, статистик ашиглах
  - Зах зээлийн чиг хандлага, өрсөлдөгч, хэрэглэгчийн мэдээлэлд дүн шинжилгээ хийх
  - Судалгааны үр дүнд үндэслэн зах зээлд нэвтрэх стратеги боловсруулах

2. Дижитал маркетинг: Брэндийг хүчирхэгжүүлж, борлуулалтыг нэмэгдүүлэх практик аргачлал

Зорилго: Бизнес эрхлэгчдэд дижитал сувгаар брэндийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, хэрэглэгч татах, борлуулалтыг өсгөх стратеги боловсруулах чадвар эзэмшүүлэх.

- **Дижитал маркетингийн стратеги боловсруулах**
  - Зорилтот хэрэглэгч, хэрэглэгчийн сегмент тодорхойлох
  - Маркетингийн зорилго, төсөв, сувгийг сонгох
  - Сошиал медиа маркетинг болон сурталчилгааны үр дүнг хэмжих
- **График дизайн ба брэнд хөгжүүлэлт**
  - Брэндийн таних тэмдэг, өнгө, фонт, визуал шийдэл боловсруулах
  - Photoshop программ ашиглан маркетингийн дизайн гаргах
- **Контент бүтээлт ба дижитал сурталчилгаанд AI ашиглах нь**
  - AI ашиглан текст, зураг, видео контент боловсруулах

СУРГАГЧ БАГШ НАР

- **Ө.Номинцэцэг (Ph.D)** – МУИС, Бизнесийн сургуулийн Дэд профессор
- **Т.Мөнх-Эрдэнэ** – МУИС, Бизнесийн сургуулийн Ахлах багш

ХЭНД ЗОРИУЛАГДСАН БЭ?

Бичил, жижиг, дунд үйлдвэрлэгч, бизнес эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага болон анхан шатны мэдлэг хуримтлуулах сонирхолтой хүмүүст зориулагдсан бөгөөд практик дадлагатай хослон явагдана.

СУРГАЛТЫН ДАВУУ ТАЛ

- Сургалтад ашиглах зөөврийн компьютероор хангана
- МУИС-ийн албан ёсны гэрчилгээ олгоно
- Онол-практик хосолсон, дасгал, бодит жишээ, кейс анализтай

СУРГАЛТЫН МЭДЭЭЛЭЛ

Хугацаа	2026.11.20 – 11.21 (Баасан, Бямба)
Цаг	09:30 – 17:00
Хэлбэр	Танхим
Байршил	МУИС, Номын сан, 406 тоот
Төлбөр	500,000 төгрөг
Бүртгэл	https://forms.gle/J9NtgR32JEghTBRh8 (2026.11.19-ний 12:00 цаг хүртэл)
Утас	75754400 (дотуур 4188), 88081117, 99191086, 89696778
И-мэйл	tselmeg_b@num.edu.mn, nomintsetseg@num.edu.mn, munkherdenet@num.edu.mn

Сургалтад хамрагдах хүний тоо хязгаартай.